



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/418

Улаанбаатар хот

“Үйлчилгээний соёл 5S-ийг хэрэгжүүлэгч” шилдэг байгууллага” аяныг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 15/06 дугаар тогтоолоор батлагдсан “Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ-2020” нийслэлийн дэд хөтөлбөрийн 2.2.2, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/480 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/220 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Дүүргийн нутаг дэвсгэрт Худалдаа, хоол үйлчилгээний газруудад “Үйлчилгээний соёл 5S-ийг хэрэгжүүлэгч шилдэг байгууллага” аяныг 2019 оны 07 дугаар сарын 25-наас 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.
2. Дээрх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс /Э.Сансар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА

Баянгол дүүргийн Засаг даргын
2019 оны ...08 дугаар сарын 07-ны өдрийн
А/418 дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Э.Батбилэг	Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагч бөгөөд Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга
Гишүүд:	Э.Сансар	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
	А.Одонтунгалагтуул	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Монголын бүтээмжийн төв Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл Аж ахуйн нэгжийн төлөөлөл
Нарийн бичгийн дарга:	Б.Бат-Өлзий	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн